

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ӨМНӨХ МЭТГЭЛЦЭЭНҮҮД (1993-2017)

Д.БАДАМДАШ
А.БАТ-ОРГИЛ

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ
2021 ОН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

© Энэхүү бүтээлийг америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтай, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд бүтээв.

Бүтээлд илэрхийлэгдсэн үзэл санаанууд нь уг бүтээлийн зохиогчдын үзэл санаа бөгөөд АНУ-ын Засгийн газар, эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.



1. Танилцуулга

Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчдийн мэтгэлцээн анх XIX зууны сүүлчээс явагдаж эхэлсэн ба улмаар АНУ-д Ричард Никсон болон Жон Кеннеди нарын дунд хийгдсэн алдартай мэтгэлцээн нь телевизийн мэтгэлцээнийг сонгуулийн сурталчилгаанд давамгайлахад хүргэсэн түүхтэй. Мэтгэлцээн нь сонгогчдын мэдэх эрхийг хангаж, өрсөлдөж буй улс төрийн хувилбарууд, хувь хүмүүс болон удирдан манлайлах чадвар зэргийг харьцуулах боломж олгоход чухал ач холбогдолтой. Мэтгэлцээний энэхүү соёл нь Монголын ардчиллын 30 жилийн түүхэнд шинээр үүсэж, өнөөг хүртэл бүрэн төлөвшөөгүй байна.

Монголд хамгийн анхны мэтгэлцээнийг тухайн үеийн нэр дэвшигч Пунсалмаагийн Очирбат болон Лодонгийн Түдэв нарын дунд явуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхны сонгуулиар явуулсан уг мэтгэлцээний үеэр нэр дэвшигчид хоёр удаагийн хэлэлцүүлэг, мэтгэлцээн хийжээ. Улс төрчид тухайн үед явуулсан хоёр удаагийн мэтгэлцээнийг сонгуулийн сурталчилгааны арга хэмжээний хамгийн чухал хэсэг нь хэмээн үзэж байв. Өнгөрсөн хугацаанд явагдсан Ерөнхийлөгчийн сонгууль бүрээр багадаа нэг удаа мэтгэлцээн зохион байгуулж ирсэн ч эдгээрийг хэт зөөлөн, хамааралгүй асуултууд асуудаг хэмээн шүүмжилсээр ирсэн. Жишээ нь, судлаач Д.Жаргалсайхан (2017) өмнө хийгдсэн бүх мэтгэлцээн нь бодит мэтгэлцээн бус, харин илүү урьдчилан бэлдсэн асуултууд бүхий ярилцлагын шинжтэй хэмээн үзжээ.

Пью судалгааны төвийн (Pew Research Center) үзэж буйгаар АНУ-д сонгуулийн мэтгэлцээн нь үндсэндээ нийт сонгогчдын гуравны хоёрт хүчтэй нөлөөлдөг байна. Гэвч мэтгэлцээн нь сонгогчдын эцсийн шийдвэрт эрс өөрчлөлт гаргахгүй байх боломжтой аж (Heimlich, 2012). Судлаач Холбруук (Holbrook, 1999) мэтгэлцээн нь ялангуяа эхэн шатандаа нэр дэвшигчдийн талаар бодит мэдээлэл өгдөг гэж үзжээ. Гэсэн ч Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн нь Монголын сонгогчдын шийдвэрт хэрхэн нөлөөлдөг талаар ямар нэгэн тодорхой нотолгоо байхгүй. Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн нь үндсэндээ санал хураалт явагдахаас 1-2 хоногийн өмнө зохион байгуулагддаг. Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн нь гарах үр дагаврын хувьд АНУ-д зохион байгуулагддаг мэтгэлцээнээс харьцангуй ялгаатай байдаг аж.

Анхны ардчилсан Үндсэн хуулийг 1992 онд баталснаас хойш Монгол Улс нь Ерөнхийлөгчийн сонгуулийг долоон удаа буюу 1993, 1997, 2001, 2005, 2009, 2013, 2017 онд зохион байгуулсан ба эдгээрийг доорх хүснэгтэд тусган харууллаа. Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчдийн мэтгэлцээнийг Монголын үндэсний олон нийтийн телевиз болон сонгуульд нэр дэвшүүлсэн улс төрийн намууд зохион байгуулж иржээ. Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчдийн мэтгэлцээнийг бүхий л сонгуулиар үндсэндээ ижил хэлбэрээр зохиож байгуулсан байна.

2. Өгөгдөл цуглуулах

Судлаачид эдгээр мэтгэлцээний үйл явцтай холбоотой бүхий л мэдээллийг боломжит бүх хэлбэрээр, жишээ нь, сонины нийтлэл, МҮОНТ-ийн видео архив, Youtube суваг, мэтгэлцээний хөтлөгчтэй хийсэн ярилцлага (гурван мэтгэлцээн хөтөлсөн) болон бусад материал байдлаар цуглуулан шинжилсэн. Сонгуулийн мэтгэлцээнийг илэрхийлэх монгол хэлний үг хэллэг ч хувьсан өөрчлөгдөж, анх халз ярилцлага хэмээн нэрийдэж байсан бол улмаар мэтгэлцээн хэмээх үгээр илэрхийлэх болсон ба судалгааны багийн зүгээс цаашид “мэтгэлцээн” хэмээх үгийг судалгаанд ашигласан.

Судлаачдын цуглуулсан материалуудын форматаас хамааран судалгааны баг нь нэгдүгээрт, мэтгэлцээнд контентын шинжилгээг хийсэн. Тухайн мэтгэлцээн нь хэр мэдээлэлтэй байсан, мэтгэлцээн нь бодлогын талаар мэдээлэлтэй сонголт хийхэд сонгогчдод дэм болсон уу гэсэн асуултад судлаачид хариулахдаа **нэр дэвшигчдийн хэлсэн зүйлсийн гол утга**, хөтлөгчдийн асуусан асуултуудын чанар зэрэгт анхаарал хандуулан судалсан.

Хоёрдугаарт, судалгааг зохион байгуулсан байдал буюу зохион байгуулагчийн хараат бус байдал, ялангуяа нэр дэвшигч бүрд хуваарилсан цаг, видео эффектийн байдал зэргийг анхааран судалсан. Үүнийг шинжлэхдээ бид нэр дэвшигч нэг бүрээс асуусан асуултын төрөл, **хэдэн минут** ярих боломж олгосон зэргийг нарийвчлан судалсан. Мөн хөтлөгчийн зүгээс мэтгэлцээний дэгийн дагуу хөндлөнгөөс зөв зохистойгоор мэтгэлцэгчийн яриаг зогсоож буй байдал, давтагдсан хэсгийг хассан байдал болон хөтлөгчийн хэрэглэсэн “бүдүүлэг” үг хэллэг, зохисгүй оролцоо зэргийг судалсан.

3. Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээний тойм

1993 оноос хойш болсон Ерөнхийлөгчийн сонгууль бүрээр багадаа нэг удаагийн халз мэтгэлцээн зохион байгуулж байсан ба судлаачид нь энэ хэсэгт мэтгэлцээн бүрийг хамруулан судалсан.

Хүснэгт 1. Санал хураалтын өдөр, мэтгэлцээний тоо, огноо.

Ерөнхийлөгчийн сонгууль	1993	1997	2001	2005	2009	2013	2017
Санал хураалтын өдөр	6 дугаар сарын 6	5 дугаар сарын 18	5 дугаар сарын 20	5 дугаар сарын 22	5 дугаар сарын 24	6 дугаар сарын 26	7 дугаар сарын 7
Нийт хийгдсэн мэтгэлцээний тоо	2	3	1	1	1	1	1
Мэтгэлцээн болсон өдөр	N/A	5 сарын 13, 14, 17	5 сарын 18	5 сарын 18	5 сарын 22	6 сарын 24	6 сарын 24

1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн



Зураг: Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн анхдугаар мэтгэлцээн. Эх сурвалж: Телевизийн мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ? (2020). Гарын авлага, Глоб Интернэшнл ТББ, Нээлттэй нийгэм хүрээлэн.

1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд зориулан тухайн үеийн төрийн мэдлийн Үндэсний телевиз Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн (Ардчилсан хүчнийг төлөөлж П.Очирбат, МАХН-ыг төлөөлж Л.Түдэв) хоёр удаагийн мэтгэлцээн/ярилцлагыг зохион байгуулжээ. Тухайн үед Үндэсний телевизийн Программын хэлтсийн даргаар ажиллаж байсан, одоо Глоб Интернэшнл ТББ-ын тэргүүн Г.Наранжаргал энэхүү мэтгэлцээнийг гардан зохион байгуулсан. Тэрбээр энэ талаар “Хамгийн анхны халз мэтгэлцээний үеэр нэр дэвшигчдээс асуулт асуулгахаар олон нийтэд танигдсан найман сэтгүүлчийг урин оролцуулсан. Хоёр дахь удаагийн мэтгэлцээнийг телевизээр шууд нэвтрүүлж, үзэгчдээс утсаар асуултуудыг авсан. Нэр дэвшигчдийн нэг болох МАХН-ын нэр дэвшигч Л.Түдэвийн зүгээс мэтгэлцээний зохион байгуулалтын талаар, ялангуяа утсаар асуулт авч буйд онцгойлон шүүмжлэлтэй хандаж байсан. Ийнхүү сэтгэл ханамжгүй байснаас болсон байх, Мэдээллийн хөтөлбөрийн дараа үргэлжилсэн хоёр дахь хэсэг дээр асуултуудад хариулахдаа өрсөлдөгчөө нэлээд дайрсан шинжтэй байсан” (Глоб Интернэшнл төв, 2020, 3) хэмээн бичсэн байдаг. 1993 онд энэхүү халз мэтгэлцээн хийгдсэнээс хойш МҮОНТВ-д видео бичлэг үлдээгүй, тухайн үеийн өдөр тутмын сонинуудад нийтлэгдсэн өгүүллүүд хадгалагдаагүй байна. Тиймээс энэхүү хоёр удаагийн мэтгэлцээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл олж авч, судлахад хүндрэлтэй байсан. Гэсэн хэдий ч мэтгэлцээн хатуу дүрэмгүй, урьдчилан бэлтгэсэн асуултуудгүй явагдсан гэж судлаачид үзэж байна. Энэхүү хамгийн анхны мэтгэлцээн нь үндсэндээ

хоёр нэр дэвшигч болон сэтгүүлч хоорондын нээлттэй ярилцлага хэлбэртэй болсон хэмээн үзсэн.

1997 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн

1997 оны Ерөнхийлөгчийн сонгуульд гурван нэр дэвшигч өрсөлдсөний тоонд Ардчилсан хүчний эвслийн нэр дэвшигч Пунсалмаагийн Очирбат, МАХН-ын (тухайн үед (2010) хоёр салаагүй, нэрээ өөрчлөлгүй хуучин нэрээ хадгалж, өнөөгийн МАН гэсэн нэрээ аваагүй байсан) нэр дэвшигч Нацагийн Багабанди, Монголын уламжлалын нэгдсэн намын нэр дэвшигч Жамбын Гомбожав нар багтсан.

МҮОНТ, Хэвлэлийн хүрээлэн болон Сонгогчдын боловсролын төв ТББ нь 1997 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар нийт гурван удаа мэтгэлцээн зохион байгуулсан. Эхний мэтгэлцээн нь тухайн үеийн Ерөнхийлөгч П.Очирбат болон МАХН-аас нэр дэвшигч Н.Багабанди нарын хооронд 1997 оны тавдугаар сарын 13-нд болсон. Хоёр дахь удаагийн мэтгэлцээн нь П.Очирбат болон Уламжлалын нэгдсэн намын нэр дэвшигч Ж.Гомбожав нарын хооронд 1997 оны тавдугаар сарын 14-нд зохион байгуулагдсан. Нэр дэвшигчид хоорондын сүүлийн мэтгэлцээн нь 1997 оны тавдугаар сарын 17-нд зохион байгуулагдсан. Энэхүү мэтгэлцээнд Сонгогчийн боловсрол төвийн сонгосон 24 сонгогч, 12 сэтгүүлч үзэгчээр оролцжээ. Мэтгэлцээний үеэр сонгогчдын зургаан төлөөлөл, зургаан сэтгүүлч нэр дэвшигчдээс асуулт асуусан байна.

Үндсэндээ мэтгэлцээний цаг нь хангалттай тооны асуултад хариулт өгөхөд хүрэлцэхгүй байсан. Нэг нэр дэвшигчид хоёр минутын хугацаанд асуултад хариулах боломж олгожээ.

Асуултауд:

- 1) Манай улсын өнөөгийн нөхцөл байдлыг та хэрхэн үнэлж байна вэ?
- 2) Шүүхийн ерөнхий зөвлөлд өөрчлөлт хийж, Хууль зүйн сайд даргалах болсон нь шүүхийн хараат бус байдлыг бууруулахад хүргэсэн үү?
- 3) МАХН нь улс төрийн хэлмэгдүүлэлт хийж, олон хүнийг хороосондоо уучлал хүсэх нь зөв гэж та боддог уу. Өнөөг хүртэл МАХН-аас ийнхүү олон нийтээс уучлал хүсээгүйг та юу гэж үзэж байна вэ?
- 4) 1993 онд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тухай хуулийн төсөл УИХ-д өргөн барьсан ч өнөөг хүртэл хэлэлцүүлээгүй байна. Та энэ ажлыг үргэлжлүүлэх үү?
- 5) Хэрэв та Ерөнхийлөгчөөр сонгогдвол таны шийдэх анхны асуудал юу байх вэ?
- 6) Уул уурхайн салбарын хөгжлийн чиглэлээр та юу хийж бүтээсэн бэ?
- 7) Бүс нутгийн хөгжилд төвлөрөх гол шалтгаан нь юу вэ? (студид буй Төв аймгийн малчин асуусан.) #)
- 8) Сүүлийн үг хэлэхэд зориулсан хоёр минут.

Асуулт 1 болон 5-аас бусад нь тухайн хүмүүсийг нэр дэвшүүлсэн улс төрийн намуудад хандсан асуулт байжээ. Асуулт 2 нь тухайн үеийн Ерөнхийлөгчөөс шүүх эрх мэдлийн чиглэлээр гаргасан шийдвэрийнх нь тухай асуулт байв. Тухайн үед Ардчилсан холбоо эсвэл УИХ-д олонхыг бүрдүүлж, тус эвслийн Засгийн газар ажиллаж байсан. 1996 онд явуулсан УИХ-ын сонгуулиар Ардчилсан холбоо эсвэл УИХ-ын 76 суудлын 50-д ялалт байгуулсан байв. Асуулт 3 болон 4 нь Н.Багабандийг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн МАХН-ын эсрэг хандлагатай асуулт байсан ба нэр дэвшигчийн зүгээс МҮОНТ-ийг тухайн үеийн Засгийн газраас хамааралтай гэж шүүмжилж байжээ. Ардын эрх (1997) сонин ч мэтгэлцээний талаар нийтлэл гаргаж, үүнд нэр дэвшигч Н.Багабанди олгосон минутыг 2-3 дахин хэтрүүлэн удаан ярьсан хэмээн шүүмжилж байжээ.

2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн

Ардчилсан холбоо эвслийн нэр дэвшигч Р.Гончигдорж, тухайн үеийн Ерөнхийлөгч, МАХН-ын нэр дэвшигч Н.Багабанди, Иргэний Зориг намын нэр дэвшигч Л.Дашням нарын мэтгэлцээн 2001 оны тавдугаар сарын 18-нд 9.30-10.45 цагт Монголын үндэсний олон нийтийн телевизээр болсон. Энэ нь Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах өдрөөс ердөө хоёр хоногийн өмнө зохион байгуулагджээ. Иргэдээс 200 гаруй асуултыг утас, факсаар урьдчилан авч, мэтгэлцээний 75 минутын хугацаанд нэр дэвшигчдэд ойролцоогоор 21-26 асуулт тавьжээ. Хүлээн авсан асуултуудыг ангилан, нэгтгэж, багасгасан байв. Нийт 60 асуултыг хэвлэн, хайрцагт хийсэн ба эдгээрээс санамсаргүйгээр сонгон авч, тухайн сонгосон асуултыг хоёр нэр дэвшигчээс асуужээ. МҮОНТ-ын хоёр сэтгүүлч, Д.Сарангэрэл (Одоогийн УИХ-ын гишүүн) болон Баярсайхан нар хөтлөгчөөр ажиллажээ.

Асуултуудад хариулах хугацаа нь нэр дэвшигч бүрд нэг минутаар хязгаарлагдсан. Хугацаа дуусахаас таван секундний өмнө хөгжим дуугаран дохио өгч, нэр дэвшигчид энэ хугацаанд амжин дуусгаагүй тохиолдолд хөтлөгчид оролцогчийн микрофоныг унтрааж байжээ. Мэтгэлцээний өмнө нэр дэвшигчид сугалаа сугалан ярих дарааллаа тогтоож, энэхүү дарааллыг нийт мэтгэлцээний туршид мөрдсөн байна. Нэр дэвшигчдийн сонгуулийн менежерүүд сугалаа сугалан ярих дараалал тогтоохыг зөвшөөрч, сугалааны дүнд нэр дэвшигч Л.Дашням эхлээд, дараа нь Н.Багабанди, Р.Гончигдорж нар хариулан, хоёр дахь асуултаас эхлэн дарааллыг сэлгэх байдлаар үргэлжилжээ.

Асуултууд:

- 1) Хэрэв та Ерөнхийлөгчөөр сонгогдвол, өмнөд болон хойд хөрштэй хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх вэ?
- 2) Хэрэв ард иргэд танд итгэл үзүүлбэл авлигатай тэмцэх чиглэлээр өөрийн эрх мэдлийн хүрээнд ямар зүйл хийх вэ?
- 3) Монгол улсад тулгараад буй асуудлуудыг ач холбогдлоор нь жагсаан нэрлэнэ үү?
- 4) Хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдалд хэрхэн хамааралтай вэ?
- 5) Өндөр үнэлгээтэй компаниудын хувьчлалын талаар та ямар бодолтой байдаг вэ?

- 6) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байраар хангах талаар та ямар зүйл хийж, хэрэгжүүлэх вэ?
- 7) Өрх толгойлсон эхчүүд хүнд нөхцөлд амьдарч байна, тэдний амьжиргааг дээшлүүлэхийн тулд та юу хийх вэ?
- 8) Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлээр та юу хийх вэ?
- 9) Та сонгодог ардчиллын баталгаа байж чадах уу?
- 10) Таны мөрийн хөтөлбөрийн бусдаас ялгагдах гол зүйл нь юу вэ?
- 11) Монголын ард түмэн ядуурлыг хэзээ даван туулна гэж та бодож байна вэ? Үүнтэй холбоотойгоор та ямар зүйл хийх вэ?
- 12) Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахын ямар зүйл хийх хэрэгтэй гэж та бодож байна вэ?
- 13) Нутгийн өөрийн удирдлагын талаар өөрийн бодлын хуваалцана уу?
- 14) Дундаж Монгол өрх хоол хүнс, хувцас, хэрэглээндээ өрхийн орлогын хэдэн хувийг зарцуулдаг вэ?
- 15) Сонгодог урлагийг, ялангуяа театрын урлагийг та хэр сонирхдог вэ, хэзээ жүжиг үзсэн бэ?
- 16) Хэрэв та Ерөнхийлөгчөөр сонгогдвол гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд та юу хийх вэ?
- 17) Чингис хаанаас өөр ямар хааныг та хүндэтгэдэг вэ?
- 18) Эдийн засгийн өсөлтийг хангахын тулд та юу хийх вэ?
- 19) Та Зэвсэгт хүчний ерөнхий командлагч болбол армид та ямар бодлого баримтлах вэ?
- 20) Хөдөө орон нутагт тулгараад буй асуудлуудад та хэрхэн анхааралд хандуулах вэ? Хөдөөгөөс хот руу чиглэсэн нүүдлийг та хэрхэн шийдэх вэ?
- 21) Сонгогчдод хандан нэг минутад багтаан үг хэлэх.

Улс оронд тулгарч буй ерөнхий асуудлуудаас гадна 15 болон 17 зэрэг хамаарал багатай асуултууд энд багтжээ. Хөтлөгчдийн зүгээс тодруулахгүй, үндсэн асуултуудад чиглүүлээгүйн улмаас нэр дэвшигчид олон асуулт дээр өөрийн мөрийн хөтөлбөрийг давхардуулах, давтах зэрэг тохиолдол гарч байжээ.

2005 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн

2005 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшсэн М.Энхсайхан, Эх орон намаас нэр дэвшсэн Б.Эрдэнэбат, Бүгд найрамдах намаас нэр дэвшсэн Б.Жаргалсайхан, МАХН-аас нэр дэвшсэн Н.Энхбаяр нарын дунд сонгуулийн мэтгэлцээнийг санал хураалтаас дөрвөн өдрийн өмнө буюу 2005 оны тавдугаар сарын 18-нд МҮОНТ-ээр явуулсан.

Асуултууд:

- 1) Өөрийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт багтсан гол зүйлсийг танилцуулна уу?
- 2) Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдлыг та хэрхэн харж байна вэ?
- 3) Монгол Улсын хөгжлийн гарц юу байх вэ?

- 4) Өнөөгийн эдийн засгийн өсөлтийг та хэрхэн үнэлэх вэ?
- 5) Ажилгүйдэл, архи дан согтуурах явдал, ядуурлын талаар та ямар арга хэмжээ авах вэ?
- 6) Хэрэв та Ерөнхийлөгч болбол авлига, хээл хахуультай та хэрхэн тэмцэх вэ?
- 7) Хэрэв та Ерөнхийлөгчөөр сонгогдвол авлига, хээл хахуультай та хэрхэн тэмцэх вэ?
- 8) Дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаарх таны байр суурь?
- 9) Гадаад өрийн талаарх таны байр суурь?
- 10) Монгол Улсын гадаад бодлогын суурь асуудал юу вэ?
- 11) Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд та юу хийх вэ?
- 12) Монгол Улсын Ерөнхийлөгч нь үндэсний эв нэгдлийн бэлэг тэмдэг байдаг. Үндэсний эв нэгдлийн талаар та юу хэлэх вэ?
- 13) Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын талаар таны бодол?
- 14) Нийгмийн болон байгалийн баялгийн шударга хуваарилалтын чиглэлээр та юу хийх вэ?
- 15) Нэг минутад багтаан сонгогчдод хандан үг хэлнэ үү.

Дахин хэлэхэд асуултууд нь ерөнхий, Ерөнхийлөгчийн чиг үүрэгт онцгой хамааралтай бус байв. Тиймээс нэр дэвшигчид нь өөрийн бодлогын онцлог сонголтуудаар өрсөлдөлгүйгээр улс оронд тулгараад буй ноцтой, чухал асуудлаар ерөнхий байдлаар хариулсан. Үүний нэгэн адил бодлогын сонголт/хувилбарууд дээр мэтгэлцээн, няцаалт гараагүй.



Зураг: Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн анхны мэтгэлцээн. Эх сурвалж: Телевизийн мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ? (2020). Гарын авлага, Глоб Интернэшнл ТББ, Нээлттэй нийгэм хүрээлэн.

2009 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн

2009 орны Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр нэр дэвшигч өрсөлдсөн ба эдгээр нь МАХН-ын (одоогийн МАН) нэр дэвшигч Н.Энхбаяр, Ардчилсан намын нэр дэвшигч Ц.Элбэгдорж нар байв. Хоёр намын зүгээс нэг удаагийн мэтгэлцээнийг МҮОНТ-ээр зохион байгуулсан. Энэхүү мэтгэлцээний үеэр МҮОНТ-д 1400 гаруй асуулт хүлээн авснаас 60-ыг нь зохион байгуулагчид сонгожээ. Нэр дэвшигчдээс 19 асуул асуун мэтгэлцүүлжээ.

Мэтгэлцээнийг нэг л хөтлөгчтэй зохион байгуулсан ба сэтгүүлч Ц.Мөнхтөр хөтлөн явуулсан. Хөтлөгчид 60 асуултын жагсаалтыг өгч, улмаар асуултуудын дугаар бүхий сугалааг хөтлөгч нь хайрцгаас сугалан гаргаж, асуух байдлаар зохион байгуулжээ. Нэр дэвшигч нэг бүрд тусгайлан хандсан асуулт байгаагүй. Нэр дэвшигч нь асуулт бүрд хоёр минутад багтаан хариулах ба төгсгөлд нь гурван минутад багтаан үг хэлэх боломжтой байсан. Мэтгэлцээний үеэр харилцан мэтгэлцэх, няцаах цаг байхгүй, нэр дэвшигчид нь харилцан асуулт асуухыг зөвшөөрөөгүй ажээ. Мэтгэлцээний үеэр оролцогчид нь нэг ижил асуултад л хариулсан. Эдгээрээс хамгийн чухал нь 2008 оны долдугаар сарын 1-ний хэргийн талаарх асуулт байсан. Студид цэнхэр өнгийн арын фон засаж, ойролцоох багануудад Төрийн далбаа байрлуулсан байв. Мэтгэлцээний үеэр дохионы хэлмэрч ажиллаагүй. Ярилцлагын үеэр техникийн зарим асуудал гарсан ба жишээ нь Н.Энхбаярыг ярьж байхад камер нь Ц.Элбэгдоржийг харуулж байсан зэрэг асуудал гарсан. Ерөнхий байдлаар нь харвал Н.Энхбаяр нь илүү сайн өнцгөөс харагдаж байв.

Мэтгэлцээний үеэр асуусан асуултууд нь үндэсний аюулгүй байдал, соёлын өв, уул уурхайн стратегийн ордууд, ажилгүйдэл, шүүх эрх мэдлийн салбар, ноолуур зэрэг бараа бүтээгдэхүүн, хүнсний аюулгүй байдал, сонгууль зэрэг төрөл бүрийн сэдвээр байсан. Жишээ нь, Асуулт 31: Та өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг хэрхэн харж байна вэ? Асуулт 54: 2008 оны долдугаар сарын 1-ний явдлыг та юу гэж үзэж байна вэ? Асуулт 49: Гадаадынханд өгсөн уул уурхайн тусгай зөвшөөрлийг цуцалж чадах уу? Асуулт 11: Шүүх эрх мэдлийн тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлын талаар та юу хэлэх вэ?

2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн

Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч, тухайн үеийн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэ болон анхны эмэгтэй нэр дэвшигч, МАХН-ын төлөөлөл Н.Удвал нарын хоорондын мэтгэлцээн сонгуулийн санал хураахаас дөрвөн хоногийн өмнө буюу 2013 оны зургадугаар сарын 24-нд болж, нийт 120 минут үргэлжлэн, МҮОНТ-ийн 1 болон 2 дугаар сувгаар шууд дамжуулжээ. Мэтгэлцээний хөтлөгчөөр МҮОНТ-ийн сэтгүүлч Б.Оюунчимэг болон Б.Баярсайхан нар ажилласан. Студид дохионы хэлмэрч мөн ажилласан. Ашигласан цаг нь их хэмжээтэй,

бага зэрэг хоцролттой байжээ. Хоцорч буйгаас шалтгаалан нэр дэвшигчдэд асуудал үүсжээ.



Хэлбэр: Нэр дэвшигчдээс урьдчилан бэлтгэсэн асуултуудыг асуусан. МҮОНТ-ийн Олон нийттэй харилцах хэлтэс зургадгаар сарын 21-24-ний 12.00 цагийн хооронд иргэдээс 373 асуулт хүлээн авснаас нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөртэй шууд хамааралтайг сонгосон. Энэхүү бэлтгэл үйл ажиллагааг нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлын багийн ажиглагчдын хяналт дор хийжээ.

Дүрэм: Нэр дэвшигч бүр нэг минутад багтаан нээлтийн үг хэлж, улмаар асуултуудад тус бүр хоёр минутад багтаан хариулах дүрмээр явагдсан. Нэр дэвшигчдийн зогсох байрлал, хариулах дэс дарааг сугалаагаар шийджээ.

Нэг асуултыг бүх нэр дэвшигчид тавьсан ба няцаах тусгайлсан цаг өгөөгүй. Нэр дэвшигчид харилцан асуулт асуухыг зөвшөөрөөгүй. Хөтлөгчдийн үүрэг хязгаарлагдмал, асуултыг л гарган ирж, асуух үүрэгтэй байв. Асуултуудын хамрах сэдэв нь өргөн хүрээтэй бөгөөд батлан хамгаалах, шүүх эрх мэдлийн салбар, улс төрийн намууд, гадаад бодлого, эдийн засаг дахь уул уурхайн салбарын үүрэг роль, соёлын өвийг хамгаалах, боловсролын салбарын хүртээмж зэргийг хамарчээ. Ихэнх асуулт нь Ерөнхийлөгчийн эрх мэдэлтэй хамаарахгүй байв.

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн

МАН-ын нэр дэвшигч Миеэгомбын Энхболд, Ардчилсан намын нэр дэвшигч Халтмаагийн Баттулга болон МАХН-ын нэр дэвшигч Сайнхүүгийн Ганбаатар нар 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн. Эдгээр нэр дэвшигч нь 2017 оны зургадгаар

сарын 24-нд МҮОНТ-ээр нэг л удаа мэтгэлцжээ. Мэтгэлцээн хоёр цаг үргэлжилсэн. Мэтгэлцээнийг МҮОНТ-ийн хөтлөгч Ч.Ичинхорлоо болон Б.Ганбаатар нар хөтөлжээ. Телевизийн студид лед дэлгэц байрлуулан, улс төрийн гурван намын далбааг харуулж байсан. Гурван өрсөлдөгч болон хөтлөгчид тусгайлан заасан индрийн ард зогсож мэтгэлцээнд оролцжээ. Мэтгэлцээний үеэр мөн дохионы хэлмэрч ажилласан.



Студид асуултууд бүхий дөрвөн хайрцаг байршуулсан ба эхний хайрцагт бүх нэр дэвшигч заавал хариулах энгийн асуултуудыг, үлдэх гурван хайрцаг нь урд хэсэгтээ нэр дэвшигч нэг бүрийн нэртэй, тухайн нэр дэвшигч бүрд тусгайлсан асуултуудтай байсан. Эдгээрийн дунд гэр бүлийн гишүүдийнх нь тухай зэрэг хувь хүнтэй холбоотой асуултууд байжээ. Асуултуудыг гурван намын төлөөллийн хяналт дор сонгожээ.

Дүрэм: Нээлтийн үг хэлэхэд зориулан нэг минут, асуултуудад хариулахад зориулан хоёр минутыг хуваарилсан байна. Телевизийн дэлгэц дээр цагийг харуулж, микрофоныг автоматаар унтрааж байв. Хөтлөгчид нь хайрцагас асуултуудыг сугалан гаргаж ирэхэд хүндрэлтэй байсан.

Хөтлөгчдийн үүрэг роль маш бага, дөрвөн хайрцагас асуулт сугалан гаргаж ирэх л үүрэгтэй байв. Асуултууд ирүүлэхийг олон нийтээс хүссэн тул хамааралгүй асуултууд олон байсан. Харилцан мэтгэлцэх, няцаахад зориулан цаг хуваарилаагүй тул оролцогчид нь бие биеэсээ асуулт асуух боломжгүй байв. Гэхдээ М.Энхболдоос асуусан асуултууд нь илүү хувь хүний зан чанарын талаар байсан бол нөгөө хоёр нэр дэвшигчээс асуусан асуултууд нь шууд, шулуун асуултууд байв.

Телевизээр дамжуулсан мэтгэлцээний талаарх ажиглалтдаа М.Жаргалсайхан (2017, 1) “Хэлбэр нь (жишээ нь, нээлт болон хаалт, дараалал, хугацаа, асуултуудыг бүлэглэсэн байдал)” сайн байсан ч нэр дэвшигчдийг тэдний үнэт зүйл/ зарчим, сонгуулийн мөрийн

хөтөлбөр, эсвэл бодлогын, хувилбаруудад нь үндэслэн, үндэслэлтэй дүгнэлт хийх боломжийг сонгогчдод олгосон Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн бус байсан” хэмээн тэмдэглэжээ. Мэтгэлцээний үеэр нэр дэвшигчид нь шийдэл ярих бус, харин харилцан муулахдаа л онцгой сайн байсныг тэмдэглэжээ.

Ямартаа ч энэхүү мэтгэлцээн нь дараах боломжуудыг нээн өгснөөр чухал ач холбогдолтой байв: “Юуны өмнө бид гурван нэр дэвшигчийг нэг дэлгэц дээр харж, тэдний олон нийттэй харилцах, ярих чадварыг харьцуулах боломж олгосон. Хоёрдугаарт, сонгогчид тэдгээр нэр дэвшигчийг буруутгадаг олон асуудлаар жишээ нь, нийслэлийн газрыг хувьд шилжүүлсэн асуудал, төрийн албыг 60 тэрбумаар арилжаалах хэрэг зэрэг асуудлаар М.Энхболдын, дээд сургууль төгсөөгүй, Фенг шуй болон мүүний шашны асуудлаар С.Ганбаатарын, төрийн өмчийг хувьчлан авсан, төмөр замын гэрээ, Сингапурын бизнес эрхлэгчидтэй тогтоосон харилцаа зэрэг асуудлаар Х.Баттулгын хариултыг сонсох боломж олгосон” (Жаргалсайхан, 2017, 1). Мэтгэлцээн нь бодлогын талаарх үр дүнтэй, сонгуулийн мөрийн хөтөлбөрт дурдсан бодлогын үнэлгээ болж чадаагүй байна. Энэ нь Ерөнхийлөгчийн албаны чиг үүргийн талаарх мэдлэг, эсвэл эсрэгээр бүх нийтээс сонгогдсон Ерөнхийлөгчийн албан бус өргөн хүрээний үүрэгтэй холбоотой байж болно.

4. Дүгнэлт, зөвлөмж

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээнийг үндсэндээ Монголын үндэсний олон нийтийн телевиз болон улс төрийн намуудын төлөөлөл, ялангуяа сонгуулийн менежерүүд зохион байгуулж иржээ. Үүний гол шалтгаан нь МҮОНТ нь өмнөх хугацаанд цорын ганц улсын хэмжээнд цацагддаг телевиз байсантай холбоотой. Үүний зэрэгцээ Сонгогчдын боловсролын төв зэрэг ТББ-г оролцуулсан мэтгэлцээн мөн явагдаж иржээ.

Дээр дурдсанчлан мэтгэлцээн нь сонгогчдын шийдвэр гаргалтад хэрхэн нөлөөлж буй талаар ямар нэгэн өгөгдөл мэдээлэл байхгүй. Гэвч 2013 болон 2017 оны сонгуулийн мэтгэлцээний үеийн телевиз үзэгчдийн мэдээллээс үзвэл тухайн мэтгэлцээнийг сонгогчид маш ихээр сонирхож байсныг харуулж байна. Максима консалтинг ХХК-ийн үзэж буйгаар 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээнийг 325 000 хүн үзсэн нь нийт үзэгчийн 32 хувь байжээ. Гэвч энэ нь тухайн үед телевиз үзэж байсан нийт үзэгчийн 50 хувь нь байсан байна. Хавсралт дээр заасанчлан 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээнийг 1 430 мянган хүн үзсэн ба энэ нь Улаанбаатар хотын нийт оршин суугчийн 43 хувь, тухайн үед телевиз үзэж байсан нийт хүний 70 хувь нь байжээ. Уг тоо нь мэтгэлцээний үзэгчдийн тоо өндөр, мэтгэлцээнийг үзсэн хүмүүсийн тоо маш өндөр байсныг харуулж байна. Бидний хийсэн ажиглалт, солилцсон саналаас харвал үзэгчдийн тоог авч үзэхээс өмнө мэтгэлцээнийг маш ихээр үзсэн байна.

1993 оны сонгуулиас бусад тохиолдолд Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн мэтгэлцээнийг нэг л ижил байдлаар зохион байгуулжээ. Оролцогчид нь индрийн өмнө зогсож, олон нийтээс цуглуулсан асуултыг хөтлөгчид асуух замаар явуулж ирсэн байна. Асуултуудын сэдвийн хамрах хүрээ нь хэт өргөн, Ерөнхийлөгчид олгосон эрх мэдлээр

хязгаарлагдаагүй байна. Зохион байгуулагчдын зүгээс мэтгэлцээнийг хараат бус болгох, асуултуудыг санамсаргүйгээр сонгох хүсэлтэй байжээ. 2001 оны сонгуулиас бусад мэтгэлцээнийг студийн үзэгчгүйгээр зохион байгуулсан байна. Эдгээр мэтгэлцээнд хөтлөгч нарын үүрэг оролцоо маш бага, хайрцгаас асуулт сугалан гаргаж ирэх л үүрэгтэй байв.

Мөн МҮОНТ-ийн хараат бус, бие даасан байдал ч эргэлзээтэй байсныг нэр дэвшигч М.Энхболд болон 1997 оны сонгуульд нэр дэвшигч Очирбат, Багабанди нараас асуусан асуултууд харуулж байна.

Сонгуулийн кампанит ажлын менежерүүд нь мэтгэлцээний ерөнхий журам, асуултуудын сонголтыг хүлээн зөвшөөрч буй ч энэ нь хараат бус, бие даасан мэтгэлцээн гэж үзэхэд хангалтгүй. Учир нь сонгуулийн менежерүүд дангаар зөвшөөрөх нь зохисгүй, зарим асуултыг хасах нь сөрөг нөлөөтэй байна.

Эрдэмтэн судлаачид, ард иргэдийн зүгээс Монгол Улсад сонгуулийн зөв зохистой мэтгэлцээн дутмаг буйг шүүмжилж иржээ. Үүний учир нь няцаалт хийх тусгайлсан хугацаа байхгүй, харилцан асуулт асуух боломжгүйд оршиж байна. Цэрэнжамц (2018, 31) зэрэг монгол судлаачдын ажигласнаар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн нь “харьцангуй” уйтгартай, нэр дэвшигч бүр нь урьдчилан бэлдсэн багц асуултал ээлж ээлжээр хариулдаг” байна.

Өмнө нь болж өнгөрсөн долоон удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулиас үзвэл нэр дэвшигчид мэтгэлцээнд оролцохоос татгалзах хандлагатай байсныг харж болно. Үүний гол шалтгаан нь кампанит ажлын хугацаа богино, цөөхөн хоногт багтаан бүх аймгуудаар тойрох шаардлага тулгардагтай холбоотой. Оролцогчид эрх баригч намын эрх ашигт үйлчилж буй МҮОНТ-ийн хараат бус байдлын талаар санаа зовниж буйгаа илэрхийлж байжээ. Тиймээс судлаач бид сонгуулийн тухай хууль болон Сонгуулийн ерөнхий хорооны журамд шинээр зүйл, заалт нэмж, мэтгэлцээний журам, хэлбэрийг зохицуулах шаардлагатайг санал болгож байна. Энэхүү заалтаар мэтгэлцээнд заавал оролцох үүргийг нэр дэвшигчдэд оногдуулах шаардлагатай.

Түүнчлэн жендерийн асуудлуудад анхаарах ёстой ба эрэгтэй, эмэгтэй хөтлөгчтэйгөөс бусдаар жендерийн хамааралтай асуултуудыг оруулж байхыг зөвлөж байна.

Эрх баригч намын нэр дэвшигчдэд хэт давуу тал олгохоос сэргийлэхийн тулд улс төрийн намууд, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачид, сэтгүүлчид, бодлого судлаачдын бүрэлдэхүүнтэй олон талт комисс байгуулан мэтгэлцээнийг зохион байгуулах, нэр дэвшигчийн сурталчилгааны багийн ажиглагчдын (Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээний комисст) үүрэг нь сонгуулийн менежерүүдээр хязгаарлагдахгүй байх шаардлагатай байна. Өөрийн бичсэн гарын авлагадаа Г.Наранжаргал (Глоб Интернэшнл Төв ТББ, 2020) мэтгэлцээн зохион байгуулах чиглэлээр чадавхыг сайжруулах шаардлагатай, ялангуяа бие даасан, хараат бус журам, зохион байгуулалтыг хангасан эрх

зүйн зохицуулалттай болох, үүнд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид бүгд оролцох үүргийг заан өгөх нь чухал болохыг тэмдэглэжээ.

Дээр дурдсанчлан өмнө болсон мэтгэлцээн нь ардчилал өндөр хөгжсөн улсуудад үр дүнтэй байсны зэрэгцээ ихэнх тохиолдолд эцсийн мөчид хийгдэж байжээ. Тиймээс бидний зүгээс нэг сонгуулийн үеэр хэд хэдэн мэтгэлцээн зохион байгуулж байхыг санал болгож байна. Мэтгэлцээний хэлбэр, баримтлах журмыг эргэн харах шаардлагатай ба учир нь өмнөх мэтгэлцээний үеэр оролцогчид няцаасан баримт нотолгоо хэлэх, харилцан асуулт асуух боломжгүй байсан. Энэхүү хэлбэрийг өөрчлөх шаардлагатай.

Хэлэлцүүлэг нь илүү хүртээмжтэй, оролцоог хангасан байх ёстой. Жишээ нь, дохионы хэлний хэлмэрч оролцуулах нь чухлын зэрэгцээ хөтлөгч, оролцогчдын жендерийн тэнцэл хангагдсан байх шаардлагатай байна. Мөн мэтгэлцээнд үзэгчдийг оролцуулснаар илүү амьд болгож, нэр дэвшигч нэг бүрийн тэгш тоотой төлөөлөл, сэтгүүлч, эрдэмтэн судлаач, ТББ-ын болон хувийн хэвшлийн төлөөлөл зэрэг хараат бус, бие даасан талуудыг оруулах шаардлагатай.

Одоогоор Монгол Улс нь найм дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулахаар бэлтгэж буй бөгөөд санал авах өдрийг зургадгаар сарын 9 байхаар төвлөсөн. Энэ удаад Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар сурталчилгааны хугацааг 14 хоног байхаар тогтоосон. Энэ богино хугацаанд нэр дэвшигчид олон аймаг, гурван том хотоор явж сонгогчидтой уулзах учраас мэтгэлцээнд оролцоход бага хугацаа үлдэж байна. Гэсэн хэдий ч олон нийтийн зүгээс өндөр хүлээлттэй, мэтгэлцээн зохион байгуулахыг хэвлэл мэдээллийнхэн шаардаж байна. Илүү дэмжлэг авах зорилгоор мэтгэлцээнд оролцдог нь хэвшил болсныг улс төрийн томоохон намууд ч харгалзан үзэх нь зүйтэй. Ямартаа ч энэ нь олон нийтийн мэдэх, сонголтоо хийхийн тулд мэдээлэлтэй байх эрхийг хангах боломж юм.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Иш татсан эх сурвалжууд

- Ардын эрх сонин (1997), 3 дугаар сарын 15, Пүрэв, Дугаар. 108 (1586), Улаанбаатар, Монгол улс
- Д.Жаргалсайхан. (2017). *Ирээдүйн Ерөнхийлөгчөө тольдох боломж - ШУУД МЭТГЭЛЦЭЭН*. Икон вэбсайт: <https://ikon.mn/opinion/10n9>
- Глоб Интернейшнл Төв (2020) “Телевизийн мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ”, Нээлттэй нийгэм хүрээлэн, Улаанбаатар, Монгол улс
- Р.Хеймлич (Heimlich, R). (2012, 9 11). *Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн сонголтод нөлөөлдөг гэж ихэнх нь үзэж байна*. Пью судалгааны төв (Few Research Center): <https://www.pewresearch.org/fact-tank/2012/09/11/most-say-presidential-debates-influence-their-vote/>
- Т.М.Холбрук (Holbrook, T. M.) (1999). Ерөнхийлөгчийн сонгуулиас авах улс төрийн сургамж. *Political Behavior*, 21(1), 67-89.
- ИТОИМ. (2017). *Олон улс ба Монгол: Ерөнхийлөгчийн сонгуулийн халз мэтгэлцээн хэрхэн явагддаг вэ*. iToim сайтаас авав: <http://itoim.mn/article/%D0%BE%D0%BB%D0%BE%D0%BD-%D1%83%D0%BB%D1%81-%D0%B1%D0%B0-%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D0%B5%D1%80%D3%A9%D0%BD%D1%85%D0%B8%D0%B9%D0%BB%D3%A9%D0%B3%D1%87%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%81%D0%BE%D0%BD%D0%B3%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%85%D0%B0%D0%BB%D0%B7/8952>
- М.Жаргалсайхан. (2017). *Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн болон түгээмэл асуулууд*. Монголиа Фокус (Mongolia Focus): <http://blogs.ubc.ca/mongolia/2017/presidential-debate-issues/>
- Б.Лхаажав. (2017). Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг судлах нь. the Diplomat <https://thediplomat.com/2017/05/previewing-mongolias-presidential-election/>
- Өдрийн сонин (2001) 2001 оны 5 дугаар сарын 18, 2001, Баасан, Дугаар. 117 (680), Улаанбаатар, Монгол улс
- М.Цэрэнжамц (2018). Цахим популизм болон сонгууль дахь олон нийтийн сүлжээний үүрэг роль, Улаанбаатар, Монгол улс

Хавсралт 1

2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээний ТВ үзэгчдийн мэдээлэл (Эх сурвалж: Максима Консалтинг ХХК)

[ХӨТӨЛБӨР] (Хувь хүн 4+Улаанбаатар)										
Нэр	Суваг	Огноо	Эхэлсэн цаг	Дууссан цаг	Рейтинг (000)	Рейтинг %	Эзлэх хувь	Дундаж үзэлт (000)	Нийт хамралт (000) [Ас]	Хамралтын хувь[Ас]
Нийт					87	8.7		175	325	32.4
Мэтгэлцээн 2013	МҮОНТ	6/24/2013	21:52:56	23:44:37	148	14.8	43.2	274	274	27.3
Мэтгэлцээн 2013	МҮОНТ2	6/24/2013	21:52:46	23:44:32	26	2.6	7.5	77	325	32.4
							50.7			

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээний үеийн ТВ үзэгчдийн мэдээлэл (Эх сурвалж: Максима Консалтинг ХХК)

Нэр	Суваг	Огноо	Эхэлсэн цаг	Дууссан цаг	Рейтинг (000)	Рейтинг%	Эзлэх хувь	Дундаж үзэлт (000)
Нийт					30	3		84
Мэтгэлцээн 2017	МҮОНТ	6/24/2017	21:00:06	23:23:05	95	9.5	27.1	161
2017 оны сонгуулийн мэтгэлцээний тухай	MN25	6/24/2017	23:04:51	23:44:02	3	0.3	0.9	49
Мэтгэлцээн 2017	TV9	6/24/2017	20:59:45	23:22:54	48	4.8	13.6	167
Мэтгэлцээн 2017	C1	6/24/2017	21:00:11	23:22:20	15	1.5	4.2	30
Мэтгэлцээн 2017	EAGLE TV	6/24/2017	20:50:52	23:52:10	26	2.6	7.9	100
Мэтгэлцээн 2017	MNB2	6/24/2017	20:59:49	23:23:02	27	2.7	7.6	46
Мэтгэлцээн 2017	HTV	6/24/2017	21:00:18	23:22:20	7	0.7	2	20
Мэтгэлцээн 2017	ETV	6/24/2017	23:21:54	23:59:43	10	1	3.9	50
Мэтгэлцээн 2017	MNC	6/24/2017	21:00:31	23:23:05	9	0.9	2.6	131
							69.8	

